



# ИТГЭЛ

(аврал одуулах)

Арван зүгийн гурван цагийн Түүнчлэн заларсан бурхан бүгдийн лагшин зарлиг таалал эрдэм үйлс бүгдийн мөн чанар болсон найман түмэн дөрвөн мянган номын цогц гарахын орон хутагт хувраг бүгдийн эрхшээсэн эзэн язгуур болон дамжлагын цог төгөлдөр ачит багш дээдэс та бүгдэд итгэмой.

Бурханд итгэмой.

Номд итгэмой.

Хуврагуудад итгэмой. \аль олон унш\

Ядам хот мандалын бурхадын чуулган нөхөр лүгэ сэлт нарт итгэмой.

Цогт итгэлт дээдэс, билгийн мэлмий төгөлдөр номыг тэтгэгч сахиус нарт итгэмой. \ гурав унш \

Багш хийгээд чухаг дээд их эрдэнэ гуравт би мөргөх хийгээд авралыг одуулмой. Та нар миний үндсийг адислаж соёрх. \ хэмээн өгүүлсэнээр авралын орнууд баясангуйгаар гэрэлд хайлаад өөрт шингэснээр адислаж байна хэмээн сана\

\бодь сэтгэлийг үүсгэх нь\

Бурхан ном хийгээд чуулган дээд нугудад бодийг хүртэл би аврал одуулмой. Алин миний өглөг тэргүүтэй үйлдсэн буян эдгээрээр амьтаны тусыг тулд бурхан бүтэх болтугай. \ гурав унш \

\дэлгэрэнгүйгээр бодь сэтгэлийг үүсгэх нь\

Авралт чухаг дээд гуравт би авралыг одуулмой.

Аливаа хилэнц бүгдийг тус тусад нь наманчилмой.

Амьтаны буянд даган баясалцмой.

Агуу бурханы бодийг сэтгэлээрээ барьмой.

Бурхан ном хийгээд чуулганы дээдэд бодийг хүртэл би итгэмой.

Өөр бусдын тусыг машид бүтээхийн тулд өнөд бодийн сэтгэлийг үүсгэж үйлдье.

Ачит бодийн сэтгэлийг үүсгэж үйлдээд амьтан бүгдийг би бээр зочин урьмуй.

Сэтгэлд зохистой дээд бодийн явдлаар замная.

Амьтаны тусыг тулд бурхан бүтэх болтугай. \ гурав унш\

\цаглашгүй дөрвийг бясалгах нь\

Амьтан бүгд амгалан хийгээд амгалангийн шалтгаан луга төгөлдөр болтугай.

Амьтан бүгд зовлон хийгээд зовлонгийн шалтгаан луга хагацах болтугай.

Амьтан бүгд зовлон үгүй амгалан луга үл хагацах болтугай.

Амьтан бүгд ойр,холод тачьяах уурлах хоёр луга хагацан тэгш дор орших болтугай. \гурав өгүүл\

\бурхан багшд хоосон чанарыг номлосны үүднээс магтан мөргөх нь\

Алин бээр шүтэн барилдаж гарсан

Устах үгүй, төрөх үгүй,

Тасрах үгүй, үргэлжлэх үгүй,

Ирэх үгүй, одох үгүй

Тусдаа утгат бус, нэг утгат бус цацралыг чухал амирлуулсан, амирлангуйг үзүүлсэн

Төгсөгсөн бурхан өгүүлэгч нарын дээд түүн дор би бишрэнгүйгээр мөргөмүй.

\угаал өргөх нь\

Түүнийг ямар мэт мэндэлсэн даруйд нь

Тэнгэр нар угаал өргөсөн мэт

Тэнгэрийн ариун рашаан усаар

Түүнчлэн лагшинд нь угаал өргөмүй.

\мандал өргөх нь\  
Газар дэлхийг үнэртнээр сүрчиж цэцгээр хучин

Сүмбэр уул, дөрвөн тив, нар сараар чимсэн үүнийг

Ариун бурханы оронд зориод өргөснөөр

Амьтан бүгд тийн ариун орныг эдлэх болтугай.

УМ САРВА ДАТА ГА ТА ИДАМ ГҮРҮ РАДНА МАНДАЛА ХАМ НИРЯА ДАЯА МИ.

УМ САРВА ДАТА ГА ТА ИДАМ ГҮРҮ РАДНА МАНДАЛА ХАМ НИРЯА ДАЯА МИ.

## **Аврал одуулахын хөтөлбөр оршивой.**

Багш болон гурван зүйл авралын дээд их эрдэнэд бишрэнгүйгээр мөргөх хийгээд авралыг одуулмой. Цаг болон ахуй үйлс бүгдэд даган барин соёрх. Энд чухаг дээд гуравт аврал одуулах ёсыг ойлгоход хялбар байгуулахад:

1. Авралыг одуулахын хэрэг хийгээд тус эрдэм.
2. Авралыг хэрхэн одуулах ёс.
3. Авралыг одуулаад ямар мэт үйлдэхийн зэргийг \журмыг\ ном луга гурав

Анхных нь: Ер нь бид нар тэргүүлэшгүйгээс орчлонд тэнүүчилснээс хүний биеийг олох нь үлгэрлэвээс зүүний үзүүрийг дээш нь харуулаад газарт хатгасан дээр юнгарыг олон атгааар цацан цацваас ганц нэг төдий зүүний үзүүрт тогтох байх л байх хэмээхээс ихэнх нь үл тогтох нь илтэд нотлогдох мэт машид ховор юм. Хүний биеийг олоод ч Бурханы шашин луга уулзахын уг гарах нь ч үлгэр урьдах луга адил. Одоо бид нар хүний биеийг олоод Бурханы шашин луга уулзахын уг гарсан энэ цагт шашин луга уулзахгүй үхвээс ундаасаж машид энэлсэн найман гишүүн төгөлдөр нуурын захад хүрээд ус уулгүй цангаж үхэхээс харамсалтай. Шашин луга уулзах эс уулзах нь шашинд орох, эс орохыг хэлнэ. Шашинд орох, эс орох нь чухаг дээд гуравт аврал одуулсан, эс одуулсны үүднээс ялгах юм. Тиймээс чухаг дээд гуравт аврал одуулах хэрэгтэй бөгөөд аврал одуулахад тус эрдэм юу байна хэмээвээс:

Аврал одуулснаар ДОТООДЫН БУРХАНТАНД БАГТАНА, САНВААР БҮГД ТӨРӨХИЙН ШҮТЭЭН БОЛНО, МУУ ҮЙЛИЙН ТҮЙТГЭР БАРАГДАХ БОЛНО, БУЯН ХЭМЖЭЭЛШГҮЙГ ХУРААНА, МУУ ЗАЯАНД ҮЛ УНАНА, ХҮМҮҮН ХИЙГЭЭД ХҮМҮҮН БУСЫН ХОРЛОЛООР ҮЛ ХӨНӨӨГДӨНӨ, ЮУ САНАСАН ХЭРЭГ БҮТНЭ, ТҮРГЭН ИЛТЭД ТӨГССӨН БУРХАН БОЛОХ тэргүүтэн тус эрдэм хэмжээлэшгүй байдаг.

Тэр нь ч чухаг дээд гуравт аврал одуулж үйлддэг бодьгал нь ДОТООДЫН БУРХАНТАН хийгээд чухаг дээд аврал одуулж үл үйлддэг ертөнцийн тэнгэрт аврал одуулж үйлддэг. Бодьгалын гадаад тэрсүүдтэн хэмээх ба авралыг одуулах нь шашинд орох хийгээд бурханы суудалд орохын үүд мэт мөн учраас Зөөлөн итгэлт багш их Зонхова бээр “БОДЬМӨРИЙН ЗЭРЭГ” –тээ шашинд орохын дээд үүд авралыг одуулахад суралцах хэмээн зарлигласан мөн. Санваарт нян-най хийгээд увшийн санваар тэргүүтэн ангид гэтэлгэх найман язгуур ба бодьсадын санваар, тарнийн санваар зэрэг байдгаас авралыг одуулахыг өмнө нь одуулалгүй санваар тэдгээрийн алиныг авсан ч үл төрөх хийгээд авралыг одуулахыг өмнө нь талбиад санваар тэдгээрийн алиныг авсан ч төрөх учраас САНВААР БҮГДИЙН ШҮТЭЭН БОЛОХ мөн юм.

Урьд “ гучингурван тэнгэр “ –ийн нэг нь үхлийн таван муу ёр тусаж үхэхэд ойртохын цагт хойд төрөлдөө гахайд төрөхийг мэдээд машид зовох болжээ. Тэгээд чухаг дээдэд авралыг хүчтэй хатуу одуулан үйлдсэнээр үхээд гахайд төрхөөс буцаад тэнгэрт төрсөн хэмээн судраас зарлигласан мэт МУУ ҮЙЛИЙН ТҮЙТГЭР НИМГЭРЭХ ХИЙГЭЭД БАРАГДАХ БОЛОХ мөн юм.

Чухаг дээдэд авралыг одуулсны буяныг дүрсэнд бүтээвээс гурван оронд үл багтах учир гурван орон ч түүний саванд багадана хэмээн судраас зарлигласан мэт буян ихийг хураах тул ХЭМЖЭЭЛШГҮЙГ ХУРААХ мөн юм.

Авралыг одуулж үйлдсэнээр гахайд төрхөөс буцаад тэнгэрт төрсөн хэмээн судраас зарлигласан мэт муу заяанаас буцаж болох учраас авралыг одуулснаар МУУ ЗАЯАНД ҮЛ УНАХ болно. Урьд нэгэн хүнд хөл нь татанхай явж үл чадах нэгэн хүү байсныг урлах нэхэхэд суралцуулсанд бага сагыг мэдэх нэгэн гарчээ. Хожим нэгэн айлд хувцасны нөхөөсийг хийлгэхээр авчирсанч түүнийг нуух нэгэн хэрэг гараад шээзгий дотор оруулаад зооринд нуусныг хулгайч бээр эд зүйлд эндүүрээд хулгайлжээ. Тэр хулгайч эд юу байгаа бол хэмээн бодоод амыг нь нээтэл татанхай хүү гарсанд хулгайч бээр үүнийг алаад ягчисыг тахья хэмээгээд алахын завдалгыг үйлдэхэд тэрбээр үнэн зүрхнээсээ бурханд авралыг одуулж үйлдсэнд бурхан ягчисанд хувилаад хулгайчид нүүрээ үзүүлж үүнийг алалгүй надад өргөхтүн хэмээн зарлигласанд түүнийг алалгүй тавьсан хийгээд бас Одсүрэн бурханы үед сүмбэр уулын давхраанд Амьсгаат ба Их – амьсгаат хэмээх хоёр лусын хаан, Яруу дуут ба Бага дуут хэмээгч хоёр гарьд байжээ. Хоёр лусыгаа хоёр гарьд нь дахин дахин хөнөөх хийгээд зовоодог байсанд хожим нь хоёр лус авралыг одуулах болон суртгаалын суурийг авсанаар хоёр гардид үл хөнөөгдөж санаа амар суух болсонд гарьд учрыг асуувал бид авралыг одуулах болон суртгаалын суурийг авсанаар энэ мэт болов хэмээн өгүүлсэнд хоёр гарди ч авралыг одуулах болон суртгаалын суурийг аваад дөрвүүлээ зохилдох болж хамтран нөхөрлөөд үхэхийн цагт ерөөлийг сайтар тависнаар бидний багшийн үед хоёр лус нь Юлхорсүрэн хийгээд Пагжэйбу,



хоёр гарди нь Жанмисан хийгээд Намтойсрай болсон хэмээн судраас номлосон мэт хорлолоор үл хөнөөгдөх болох учир ХҮМҮҮН ХИЙГЭЭД ХҮМҮҮН БУСААР ҮЛ ХӨНӨӨГДӨХ мөн юм.

Үйл юу үйлдсэндч чухаг дээдэд зүрхнийхээ угаас авралыг одуулаад оюунаа даатгаад бүтээдэг тэнцэшгүй их Жову хийгээд Гаадамбын дээдэс нарын гарын авлагад суралцваас үйлдвэр бүгд эцэстээ хүрэх болох учраас ЮУ САНАСАН ХЭРЭГ БҮТЭХ мөн юм.

Чухаг дээдэд авралыг одуулахыг ёсчлон үйлдсэний хүчээр хойд төрлүүддээ чөлөөгүй оронд үл төрж ном төгөлдөр ялгамжаатай сайн шүтээнийг олох хийгээд шүтээн \бие\ түүндээ ч авралыг одуулах тэргүүтэнд суралцаад бурханы хутгийг амар хялбар олох тул ТҮРГЭН БУРХАН БОЛОХ мөн болой.

ХОЁРДУГААРТ: Авралыг хэрхэн одуулах ёсонд :

- а) Алинд авралыг одуулах авралын орон
- б) Яагаад авралыг одуулах шалтгаан
- с) Хэрхэн авралыг одуулахын санаа гурав.

2-а. Анхных нь:

Гадаадын тэрсүүд нар эсрэн тэнгэр, хурмаст тэнгэр, кришна, вишнү, нар, сар тэргүүтэнд авралыг одуулах хийгээд эгэл төрөлхтөн тийн ялгаа юу ч үл мэдэгч нар тэнгэр тэдгээрээс ч хүч чадал багатай тэнгэр, лус, газрын эзэн, ягчис, бэрд тэргүүтэн аль нэгэнд авралыг эрэх байх боловч ертөнцийн эгэл жирийн тэнгэр лус газрын эзэн бүү хэл ертөнцөд хүч чадал ихтэй эсрэн хийгээд хурмаст ба кришна тэргүүтэн ч орчлонгийн аюулаас аврах ашдын авралд зохисгүй. Түүний учир шалтгаан нь тэдгээр тэнгэр хүч төгөлдөр урьдын үйлийн хүчээр ертөнцөд түр нэг хүч чадал ихтэй болсон ч орчлонгийн хүлээснээс гэтлээгүй, орчлонгийн шаварт шигдсэнчлэн мөн хийгээд урьдын үйлийн шидэлт барагдваас үхэн егүүдээд хүний боолын ч боол болон түүнээс ч доор адгуус ба бэрд, тамын оронд ч төрдөг хэмээн судраас зарлигласан. Үлгэрлэвээс өөрөө шаварт шигдсэн хүн нэгэн бээр шаварт шигдсэн бусдыг гаргаж үл чадах луга адил юм. Тэгвэл ашдын авралд хэн зохистой вэ? хэмээвээс энэхүү төгсгөсөн ялж төгс нөгчсөн бурхад ашдын авралд зохистой. Түүний учир шалтгаан нь тэдний лагшин нь билэг найргаар чимэглэгдсэн зарлиг нь жаран гишүүнт эгшиг луга төгөлдөр, таалал нь юм бүгдийг илтэд болгоосон хийгээд амьтан бүгдийг эх нь ганц хүүгээ хайрлах мэт энэрсэн, хүч чадал чадамж нь ертөнцийн тэнгэр, лус, загарвадын хаан тэргүүтэн хүч чадал их юу адил нэг мөн боловч цаашид халирах хийгээд жигээрэмших хэрэггүй ба наашид зарлигийг нь магтаж үйлддэг, үйлс нь огторгуйн энгээр түгсэн учраас агуу их хийгээд нэгэн агшинд орох учраас түргэн, шамдал хичээлд үл харгалзах аяндаа бүтсэн, заримдаа гарч заримдаа гарах бус учраас үргэлжид тасралтгүй тэргүүн эрдэм санаанд багташгүйг эрхшээсэн хийгээд товчилвоос гэмийн язгуур бүгд луга хагацаж эрдэмийн язгуур бүгдийг гүйцээсэн мөн болой.

Бурхан ялж төгс нөгчсөн авралд зохистой учраас түүний үзүүлсэн ном чухаг дээд ч авралд зохистой. Түүний учир шалтгаан нь бурхан эрдэм хэмжээлшгүй эрхшээсэн тэр нь уг үгүй шалтгаан үгүйгээр гарсан биш юм. Эшийн номыг сонсох санах хийгээд онолын ном хорих мөрийн үнэнийг бясалган бүтээж үйлдсэнд шүтээд түйтгэрүүдийг дэс дараалчлан тэвчиж эрдмүүдийг дараалчлан гүйцээгээд илтэд төгсгөсөн бурхан болсон мөн юм. Ном чухаг дээд авралд зохистой учраас түүнийг анхааран авагч ширвага, барадигабуд, бодьсадын хутагт хуврагууд ч авралд зохистой. Түүний учир шалтгаан нь ном чухаг дээд хорих мөрийн үнэнүүд бүтээгч үгүйгээр гарсан бус шарвага, барадигабуд, бодьсадын хутагт нар бээр бясалган бүтээж үйлдсэнд шүтээд гарсан учраас ном чухаг дээд хуврагад харгалзах мөн юм. Тийм учраас чухаг дээд гурав нь алинд авралыг одуулахын орон мөн.

#### 2-6. ЯАГААД АВРАЛЫГ ОДУУЛАХ АВРАЛЫН ШАЛТГААН НЬ:

Одоо бид нар төрөх, хөгшрөх, өвдөх, үхэх, садан гуа луга хагацах дайсан гуа бус луга учирах, хүссэнээ эрээд үл олох, хүсээгүй нь дээрээс нь буух тэргүүтэн элдэв янзын зовлонг амссаар байгаа мөн бөгөөд урьд хураасан элдэв янзын нүглийн үйлдсэн үндсэнд байгаагийн дээр одоо ч ихэнхдээ арван нүглийг үйлдсэн учир хойд төрөлдөө муу заяанд одох нь гарцаагүй. Муу заяанд төрвөөс тамд машид бадарсан төмрийн сууринд түлэгдэх хийгээд цаст уулаар хүрээлэгдсэн мөсний хөндийд даарах зэрэг халуун нүйтэн, бэрдэд олон жилээр идээ ундааны нэр төдийг ч үл сонсох өлсөх цангах, адгуусанд жижгүүд нь олноор арьснаас нь чөмгөнд нь тултал идэх тэргүүтэн нэг нэгийгээ идэх хийгээд даахгүй ачаагаар ачигдан эдлэгдэх тэргүүтэн зовлон санаанд

багташгүйг цаг галавыг дуустал ч амсах байдаг. Одоо зуны наранд халах, өвлийн жаарт даарах, нэг хоёр өдрийн өлсөх цангах, нүнд ачааг үүрэх, алба улаанд одох тэргүүтэн өөрийн эрх гарваас тэсэх нэг ч байхгүй үүгээр жишэн муу заяаны зовлон хүчтэй хатуу өнө удаан тэр адилыг яаж тэсэх билээ хэмээн санаад ХОЙДЫН ЗОВЛОНГООС АЙСАН ОЮУН ХҮЧТЭЙ ХАТУУ болон зовлон түүнийг амсахыг эс хүсвээс түүнээс аврах аврал нэгийг шүтэх хэрэгтэй тул чухаг дээд гуравт түүнээс аврах чадал байгаа хийгээд өөрийн талаас аврулд бариваас магадтай аврана хэмээн СЭТГЭЛ ИТГЭМЖИЛСЭН ОЮУН ХҮЧТЭЙ ХАТУУТ ТӨРҮҮЛЭХ хоёр нь авралыг одуулахын уг шалтгаан мөн юм.

## 2-в. ХЭРХЭН АВРАЛЫГ ОДУУЛАХ САНАА НЬ:

Өмнөхүүдийг сайтар санасаны агаараас авралын орон чухаг дээд гурваас ангид горьлох авралын орон бусад надад байхгүй учраас энэ хойд нас алинд ч миний жаргах зовохыг чухаг дээд гурав та өөрөө болгоо хэмээн чин зүрхнийхээ ёроолоос чухаг дээд гуравт оюунаа даатгасан санаа тэр нь авралыг одуулахын санаа мөн юм.

ГУРАВДУГААРТ АВРАЛЫГ ОДУУЛААД ЯМАР МЭТ ҮЙЛДЭХИЙН ЗЭРЭГ \ЖУРАМ\ НЬ: \тус тусын зургаан суртгаал\ ХОРИХ ГУРВАН СУРТГААЛ Ертөнцийн тэнгэр алинд ч түр зуурын нөхрийг эрэх төдийгөөс ангид оюунаа даатгасан авралд үл барина. Хүн хийгээд адгуус тэргүүтнийг цохих хүлэх зэргээр санаа болон үйлдлээр хорлон хөнөөхийг тэвчинэ. Чухаг дээд гуравт сэтгэл үл итгэж хочлон гүжирдэгч нартай санаа үйл зохилдон

нөхөрлөн нийлж үл болно. БҮТЭЭХ ГУРВАН СУРГААЛ Бурханы лагшингийн дүрс зурмал ба шуумалын уг хийгээд урлал нь сайн муу юу адил нэг болсон ч гэм зүүх, хазгай газарт тавих хийгээд барьцаанд оруулах тэргүүтэн үл бишрэх болон муушаах аргыг тэвчээд бурхан бодьтойн хуран мэдлээр хүндэтгэлийн оронд барина. Нэг шүлгээс дээш номын үгийг алхаж гишгэх болон барьцаанд оруулах, эд өлөгт үйлдэх, хазгай газарт тавих тэргүүтнийг үл үйлдэж ном чухаг дээд бодьтойн хуран мэдлээр хүндэтгэнэ. Тойн хуврагийн тэмдэг төдий барьсанаас дээшид хочлон муулах хийгээд дайсанд харах тэргүүтэн үл бишрэхийг тэвчээд хувраг чухаг дээд бодьтойн хуран мэдлээр хүндэтгэлийн оронд барих бөгөөд тус тусын зургаан суртгаал болой.

**НИЙТИЙН ЗУРГААН СУРТГААЛ НЬ** Чухаг дээд гурав тус тусын ялгамжаа хийгээд эрдмийг нь даган дурьдаад дахин дахин авралыг одуулна. Зарлигийн ачийг нь даган дурьдаад цаг үргэлжид тахихад хичээх хийгээд юу идсэн юу уусны дээжээр тахина. Их нигүүлсэнгүй сэтгэлээр амьтан бусдыг ч ёс энэ мэтэд оруулна. Ямарваа үйлийг үйлдэх хийгээд хэрэг юуг бүтээсэн ч чухаг дээдийг тахиад соёрхол тавихаас ангид ертөнцийн аргыг тэвчинэ. Авралыг одуулахын тус эрдмийг санаад өдөр шөнийн зургаан цагт авралыг одуулж үйлдэнэ.

Чухаг дээдийг аминдаа тулсан ч үл орхих хийгээд зүрхнээсээ орхиогүй мөн боловч инээдэм наадам төдийн тулд ч орхих үгийг үл өгүүлэх бөгөөд нийтийн суртгаал зургаад ёсчлон суралцах нь авралыг одуулаад ямар мэт үйлдэхийн зэрэг юм. Тэр нь ч авралыг одуулахын хэрэг хийгээд тус эрдэмийг эс мэдвээс дуршил хүчтэй үл ирнэ. Авралын орны эрдмийг эс мэдвээс сүсэг бишрэл ихээр үл төрнө. Авралыг одуулахын учир шалтгааныг эс санаваас аврал одуулж

үйлдсэн ч дуураймал төдий нэгээс авралыг одуулахын санаа хүчтэй хатуу үл ирнэ. Авралыг одуулахын санаа эс төрвөөс аврал одуулсан ч үг төдийгөөс ангид мөн чанар нь эс гарна. Авралыг одуулахын сургаалд эс суралцваас үлгэрлэвээс дайсанд баригдаад хохирсон нэгэн хүн дайсан түүнээс аварч чадах нэгэн хүнд итгэлийг эрэхэд тэрбээр аварч үйлдэхдээ дайсанд хохирсон түүнд арга замыг зааж үйлдсэнийг ёсын дагуу эс үйлдвээс аврагдаж үл чадах луга адил. Тиймээс эдгээрийг урьд нь өөрөө магадлан үйлд. Тэгээд дахин дахин санаж сэтгэлдээ нийлүүлэн үйлд. Тэгээд авралыг одуулж үйлдэх бүртээ урьд нь санах хэрэгтэй зүйлүүдийг санахын агаараас аврал одуулахын сэтгэлдээ нийлүүлэн магадлаж үйлдэх хийгээд цаг үргэлжид суртгаалуудыг марталгүй тухайн үест нь тааруулан авал орхилыг ёсчлон үйлдвээс авралыг одуулах нь жинхэнэ ёсын дагуу гарах мөн юм. Тэдгээр үгүйгээр багш дор итгэмой хэмээх тэргүүтнийг үг төдий тоолоход үгийг өгүүлсний тус эрдэм төдий гарах боловч авралыг одуулах баттай гарахын газаргүй. Авралыг одуулахын суртгаал эдгээр нь ёсчлон суралцахад машид бэрхтэй ч бэрх учраас хаанаас чадах билээ хэмээн оюунаараа зөнд нь орхилгүй цаг үргэлжид аль чадахаараа үйлдэх хийгээд хэрвээ харшлах зүйл гарваас түүнийг гэм эрүүтгэйд үзэн гэмшихийн сэтгэлээр наманчилах хийгээд хойшид үл үйлдэх боомтлох сэтгэлийг төрүүлвээс гэм нь багасах учраас тэр мэт үйлдээрэй. Тиймээс эдгээр нь номлох ном ба ойлгохын орон төдий биш хэрэг утгын эрхэм гэж баримтлах хэрэгтэй.

ОДОО АВРАЛЫН ОРНЫГ ТОДРУУЛАН ТАЛБИХ ТЭРГҮҮТЭН ЗОРИГДОЛЫГ ЯМАР МЭТ ӨГҮҮЛЭХ НЬ авралын орныг тодруулан талбихдаа нийт арван зүгийн орон хязгаарлашгүйд чухаг дээд гурав хэмжээлшгүй буй тэр бүгдийг сэтгэлийн оронд байгуулаад авралыг одуулж үйлдэх хийгээд өмнийн огторгуйд тодруулан талбиад авралыг одуулж үйлдэх тэргүүтэн олон ёс байдгаас алийг нь үйлдсэн ч болох боловч анхлан суралцагчдад эхнийх нь хэтэрхий агуу учраас сэтгэлийн оронд ургах бэрхтэй хийгээд сүүлийнх нь арай ургахад хялбар учир сүүлийнхийн дагуу өгүүлвээс авралыг одуулахын тус эрдмийг дурдахын агаараас өөрийн өмнийн огторгуйд арслант ширээ, лянхуа, нар, саран суудлын дээр өөрийн үндсэн багш луга ялгалт үгүй ялж төгс нөгчсөн бурхан багш, түүний язгуур болон дамжлага багш нар, түүний гадуур сандуй, дэмчог, жигжид гурав тэргүүтэн ядамын хот мандалын бурхадын чуулган, түүний гадуур маналын долоон бурхан тэргүүтэй хувилгааны лагшингийн байдалтай бурхад, түүний гадуур ойрын найман бодьсад тэргүүтэй бодьсатва нар, түүний гадуур арван зургаан архад тэргүүтэй шарвага брадигабуд нар, түүний гадуур гонбо, чойжоо, лхам, намсрай тэргүүтэй номыг тэтгэгч нараар хүрээлэгдсэн үүлний цогц жигдэлсэн мэт нүүрээ бидэн луга харуулаад оршиж байна гэж сана. Өөрөө орчлонгийн зовлонгоос айгаад эрдэм хэмжээлшгүй луга төгөлдөр багш болон чухаг дээд нар зовлон түүнээс аврах чадал луга төгөлдөр учраас аврахуйд сэтгэл итгээд итгэл аврал өмөг саданд барьж байгаа мөн тул та нар болгоо хэмээхийн агаараас:

Багш дор итгэмой \авралыг одуулмой\

Бурхан дор итгэмой

Ном дор итгэмой

Хувраг дор итгэмой хэмээн авралыг одуулахын дөрвөн хүрээг аль олон унших хийгээд төгсгөлд нь:

Ядам мандалын бурхадын чуулган нөхөр лүгэ сэлт нарт итгэмой. Цогт итгэл дээдэс номыг тэтгэгч сахиус нарт \авралыг одуулмой\ итгэмой хэмээн нэрийдсэн авралыг одуулахын зургаан хүрээг долоо юмуу гурав тэргүүтэн өгүүл. Энэ үест авралын орнуудаас гэрэл хэмжээлшгүй цацраад өөрт туссанаар тэргүүлшгүйгээс хураасан муу үйлийн хилэнц түйтгэр авьяас луга сэлт бүгд арилаад ариуслаа хэмээн санаарай. Тэгээд багш хийгээд чухаг дээд их эрдэнэ гуравт би мөргөх хийгээд авралыг одуулмой. Та нар миний үндсийг адислаж соёрх хэмээн өгүүлснээр авралын орнууд баясангуйгаар гэрэлд хайлаад өөрт шингэснээр адислаж байна хэмээн сана.

Бурхан чухаг дээд хийгээд ном чухаг дээд, чуулганы дээд хувраг чухаг дээд нарт би бодийг олохыг хүртэл аврлыг одуулах хийгээд миний өглөг өгсөн тэргүүтэн буяны үндэс юу хийгээд юу үйлдсэн эдгээрийн хүчээрарьтан бүгдэд туслах хийгээд амгаланг бүтээхийн тулд үнэнхүү төгсгөсөн бурханы хутагийг түргэн олох болтугай хэмээхмйн агаараас:

Бурхан ном хийгээд чуулганы дээдүүдэд



Бодийг хүртэл би аврал одуулмой.

Алин миний өглөг тэргүүтэй үйлдсэн буян эдгээрээр

Амьтны тусын тулд бурхан бүтэх болтугай хэмээн өгүүлээд бодь сэтгэлийг үүсгэ. Сэтгэлийг үүсгэхийг товчлон хурааваас үүгээр ч болох хийгээд дэлгэрэнгүйг хүсвээс урьдахтай адил санааны үүднээс

Авралт чухаг дээд гуравт би авралыг одуулмой

Аливаа хилэнц бүгдийг тус тусад нь наманчилмой

Амьтны буянд даган баясалцмой

Агуу бурханы бодийг сэтгэлээрээ барьмой

Бурхан ном хийгээд чуулганы дээдэд

Бодийг хүртэл би итгэмой

Өөр бусдын тусыг машид бүтээхийн тулд

Өнөд бодийн сэтгэлийг үүсгэж үйлдье

Ачит бодийн сэтгэлийг үүсгэж үйлдээд

Амьтан бүгдийг би бээр зочинд урьмуй

Сэтгэлд зохистой дээд бодийн явдлаар замная

Амьтны тусын тулд бурхан бүтэн болтугай хэмээн өгүүл.

Амьтан бүгд орчлонгийн зовлонгоос гэтэлж цувиралт үгүй амгалан хийгээд амгалангийн шалтгаан луга төгөлдөр болтугай, орчлонгийн зовлон хийгээд

“бүхэн гарах” буюу зовлонгийн шалтгаан үйл хийгээд нисвэнис бүгд луга хагацваас юунд болохгүй байх вэ дээ хагацах болтугай, ашид зовлон үгүй цувиралтгүй амгалан луга үл хагацваас юунд болохгүй байх вэ дээ үл хагацах болтугай, зарим нэгнийг ойр бариад тачаах хийгээд зарим нэгнийг холд

бодоод уурлах хоёр луга хагацаж бүгдэд сэтгэл тэгшитгэсэн тэгш дор оршвоос юунд болохгүй байх вэ дээ орших болтугай хэмээхийн агаараас

Амьтан бүгд амгалан хийгээд амгалангийн шалтгаан луга төгөлдөр болтугай.

Зовлон хийгээд зовлонгийн шалтгаан луга хагацах болтугай

Зовлон үгүй амгалан луга үл хагацах болтугай

Ойр холд тачаах уурлах хоёр луга хагацсан тэгш дор орших болтугай хэмээн өгүүлээд цаглашгүй дөрвийг бясалгаж үйлдээрэй.

Энэ бүгдийг заавал нэг дор унших хэрэг үгүй учраас зав байгаа үедээ энэ адил үйлдээд зав үгүй болвоос зөвхөн авралыг одуулахыг үйлдсэн ч болохгүй юм үгүй тул тухайн үед нь тааруул. Тиймээс зав чөлөө байгаа үедээ тус эрдмийг нь санаад өмнийн огторгуйд авралын орныг тодруулан талбих тэргүүтэн зоригдолын зэргийг бясалгаж авралыг одуулахын үгийг тоонд бариад хэлэндээ өгүүлэх хийгээд төгсгөлд нь залбирал хийгээд зоригдолуудыг бясалгаж үйлд. Явах суух явдлын мөр хийгээд үйл үйлдвэр тэргүүтний үест ч авралт багш чухаг дээд өөрөө болгоо хэмээхийн санаа ая аяндаа дахин дахин гарваас авралыг одуулахын үгийг хэлэндээ өгүүлэх хийгээд зоригдолын зэрэг дэлгэрэнгүй гараагүй ч авралыг одуулж үйлдсэн болох учраас зав чөлөөндөө тааруулан авралыг одуулж үйлдэх ёсыг мэдэн үйлдээд анхааран авч үйлдвээс харшлахын шалтгаан бүгд амирлах ба хүссэн хэрэг бүгд бүтэх учраас ашиг тус ихтэй хийгээд үйлдэх ёс бага сага гарсан гараагүйд шүтээд тухайн үедээ үймцэх ба хойддоо муу заяанд одох тэргүүтний хохь бага бөгөөд эд зүйл элдэв зай бүрдүүлэх, гарын авлага нь үзэхийн дамжлага байдаг болон ялгамжаатай орон цаг үе зэрэг хэрэггүй учраас үйлдэхэд хялбар гүнзгий ном энэ мэтэд шүтээд ахуй үес хийгээд эцсийн хэрэг бүгдийг бүтээх боломж байгаа нь хувь төгөлдөр мөн учраас үүнд шамдаж үйлдээрэй.

Хэмээсэн үүнийг язгуур үндэс, хүч доривжолгоо, дур сүсэг, хичээнгүй хотол чуулсан харчэн Галсан эфү ван бээр авралыг одуулах зоригдолын зэрэг дэлгэрэнгүй хийгээд ойлгоход хялбар нэгийг туурвина уу хэмээн айлтгасаны дагуу эгэл хөгшин лам АГВААНЛОВСАНЧОЙДАНБАЛСАМБУУ бээр төвдийн ном бурханы өргөөнд найруулсаны бичээч нь хичээнгүй, санваар, тийн ажиглал уужим гэлэн Балсан болой.